



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.06 № 01/758
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДАШЗЭВЭГИЙН БАТХҮРЭЛ ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Дашзэвэгийн Батхүрэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Дашзэвэгийн Батхүрэлийн ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Дашзэвэгийн Батхүрэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (2.. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Дашзэвэгийн Батхүрэлд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд.

Хавсралт 2.. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймгийн 2024 оны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч Дашзэвэгийн Батхүрэлийн мөрийн хөтөлбөр

Зорилго: Хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, өөрийн мэдлэг туршлагыг орон нутгийн хөгжил дэвшилд зориулж, Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг орон нутгийн түвшинд хангуулахад оршино.

Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх талаар дараах асуудлуудыг хэрэгжүүлэн ажиллана.

1. Төсвийн талаар.
 - 1.1 Батлагдсан төсөв болон орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг зөв зохистой зарцуулахад анхаарал хандуулж, төсвийн хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
 - 1.2 Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн сонгон шалгаруулалт, санхүүжилт, эргэн төлөлтөнд хяналт тавьж ажиллана.
 - 1.3 Орон нутгийн орлогыг бүрэн тодорхойлж, хувиарлалт, зарцуулалтыг оновчтой болгож, тооцоо судалгаагүй, үрэлгэн явдлыг таслан зогсооно.
2. Орон нутгийн өмчийн талаар.
 - 2.1 Орон нутгийн өмч хөрөнгөнд тооллого хийж ашиглалт хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллана.
 - 2.2 Шинээр олж авах хөрөнгөний хэрэгцээтэй эсэх талаар иргэдэд мэдээлж, тэдний саналыг тусган, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангана.
3. Газрын тухай.
 - 3.1 Газрын тухай хуульд заасны дагуу иргэн хоршоолол, аж ахуйн нэгжид газар өмчлүүлэх, эзэмшүүлэх ажилд өөрийн санал санаачлагыг тусган, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
 - 3.2 Газар зохион байгуулах төлөвлөгөөнд өөрийн санал санаачлагыг тусган, хэрэгжилтэнд хяналт тавина.
4. Ойн тухай.
 - 4.1 Иргэн, аж ахуйн нэгжид хэрэглээний модны хувиарлалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.
 - 4.2 Ойн дагалт баялгийг зөв зохистой ашиглах, хамгаалах тал дээр нутгийн ирдтэй хамтран ажиллана.
 - 4.3 Ойн санг хортон шавьжнаас хамгаалах талаар санал санаачлага гарган ажиллана.
5. Төрийн байгууллагуудын талаар.
 - 5.1 Олон улсын жишигт нийцсэн ISO 9001 чанарын удирдлагын нэгдсэн тогтолцооны стандартыг хэрэгжүүлэхийг дэмжиж, иргэдийн хүлээлт, хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүнээр үйлчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
 - 5.2 Боловсролын талаар.
 - 5.2.1 Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд анхаарна.

3. Дг




5.2.2 Боловсролын байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, дэмжих, урамшуулах аргаар өндөр ур чадвартай мэргэжилтэн, багш нарыг бэлтгэн тогтвор суурьшилтай ажиллуулахад санал санаачлага гарган ажиллана.

5.3 Эрүүл мэндийн талаар.


5.3.1 эрүүл мэндийн стандартыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд анхаарч, эмчилгээний үр дүнг сайжруулна.


5.3.1 Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, дэмжих, урамшуулах аргаар өндөр ур чадвартай мэргэжилтэн, эмч нарыг бэлтгэн тогтвор суурьшилтай ажиллуулахад санал санаачлага гарган ажиллана

Боловсруулсан



Д.Батхүрэл



3. 

0000000000?